# Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр

## Барилга, хот байгуулалтын яам

## 2021 оны жилийн эцэс

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 1 | 2.1.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна. | 11. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | 2021 - 2024 | 441.08 сая төгрөг, Улсын төсөв | Нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулж батлуулсан байна. | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 169 дүгээр тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд энэхүү жагсаалтад заасан "Сүрьеэгийн 30 ортой эмнэлгийн зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл"-ийг боловсруулж дуусган, магадлалын хийлгэн, хүлээн авсан . Зооноз өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг төслийг шинээр боловсруулж батлуулсан. Архангай, Төв, Ховд, Увс, нийт 4 аймгийн нутаг дэвсгэрт батлагдсан нэг маягийн зургийн дагуу барилга барихаар төлөвлөж, зураг төсөлд холболт хийх зургийн ажлыг Хатанбаатар ХХК гүйцэтгэж байна.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 2 | 2.1.12. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга | 6. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг | 2021 - 2024 | Эрүүл мэндийн төв - 132.6 сая төгрөг, Улсын | Нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулж батлуулсан | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 169 дүгээр тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд энэхүү жагсаалтад заасан 2021 онд хэрэгжүүлэх "Эрүүл мэндийн төв" /10, 15, 22 ортой/-ийн нэг маягийн зураг төсөл, "Аймгийн нэгдсэн эмнэлгийн зориулалттай барилгын нэг маягийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | зохион байгуулна. | | төсөв | байна. | зураг төсөл" /100 ортой/-ийг тус тус иж бүрэн боловсруулж дуусган, магадлалын үе шатны ажил хийлгэж холбогдох яаманд хүлээлгэн өгсөн.<br><br>Хавсралт : 2 файл | |
| 3 | 2.1.14. Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно. | 2. Сумдын эмнэлэгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах зураг төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. | 2021 - 2022 | | Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан байна. | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 174 тоот тушаалаар "Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн төсөл арга хэмжээ" арга хэмжээний хүрээнд сумдад дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээг барьж, нүхэн жорлонтой сумдын эмнэлгийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж хоногт 6м3, 12м3 бохир ус цэвэрлэх бага хүч чадлын септик технологийн цэвэрлэх байгууламжид холбоход Боловсролын байгууллагын барилгын ариутгах татуургын "Цэвэрлэх байгууламж /шингээх/" нэг маягийн батлагдсан зураг төслийг ашиглахаар нэг маягийн зураг төслийг 2021.06.22-ны ЭМЯ-нд 3/2476 тоот албан бичгээр хүргүүлсэн. Зураг төслийн дагуу ЭМ Сайдын багцад нийт 24 тэрбум, үүнээс 2022 онд 3.0 тэрбум төгрөгийн санхүүжүүлэхээр батлагдсан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 4 | 2.2.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга | 8. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | 2021 - 2024 | 93 сая төгрөг | Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан байна. | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 169 дүгээр тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд энэхүү жагсаалтад заасан сургуулийн спорт заал /540 м2, 720м2/ -ны нэг маягийн зураг төслийг боловсруулж батлагдсан зураг төслийг 650/2021, 647/2021 дугаар бүхий магадлалын дүгнэлтийн хамт БШУЯ-нд хүлээлгэж өгсөн.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууламжийг барина. | | | | | | |
| 5 | 2.3.9. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ. Үүнд: - 273 цэцэрлэг ашиглалтад оруулах, - 200 шинэ сургууль ашиглалтад оруулах, - Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх, - Жил бүр нүхэн жорлонтой 100-аас доошгүй цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин | 7. Барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | 2021 - 2024 | 1,478.6 сая төгрөг, Улсын төсөв | Захиалгын дагуу нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна. | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх 29, шилжин хэрэгжүүлэх 75 цэцэрлэг, шинээр хэрэгжих 14, шилжин хэрэгжүүлэх 85 сургуулийн барилга угсралтын ажлын санхүүжилт тусгагдан батлагдсан. Энэхүү ажлын хүрээнд /50, 150, 200 хүүхдийн ортой/ цэцэрлэгийн барилга, "Бага сургууль /160 суудалтай/-ийн барилга, Ерөнхий боловсролын дунд сургууль /320, 640 хүүхдийн суудалтай/ сургуулийн барилга, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилга, дотуур байр /100,160 ортой/ барилга, Сургуулийн спорт заалны барилгын нэг маягийн зураг төслийг тус тус боловсруулж дуусган, магадлалын 643/2021, 644/2021, 645/2021, 646/2021), 642/2021 дүгнэлтгээр баталгаажуулсан. Дээрх зураг төслүүдийг холбогдох яамдуудад актаар хүлээлгэж өгсөн.<br>Хавсралт : 1 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үеийн ариун цэврийн байгууламжтай болгох. | | | | | | |
| 6 | 2.6.1. Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна. | 7. Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр | 2021 - 2024 | 40,5 сая төгрөг | Хүүхэлдэйн театр, хүүхдийн номын сангийн газрын асуудлыг шийдвэрлэнэ. Барилгын зураг төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XI.4.2-т тусгадсан батлагдаж, БХБСайдын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 32 дугаар тушаалаар баталгаажсан “Номын сангийн барилгын нэг маягийн зураг төсөл”-ийн боловсруулалтын ажлын эскиз зургийг Соёлын яамтай зөвшилцөж баталсан. Зураг төслийг боловсруулсан, магадлалаар баталгаажуулан Соёлын Яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Хүүхэлдэйн театр, хүүхдийн номын сангийн ажлыг Соёлын яам хариуцан ажиллаж байгаа.<br><br>Хавсралт : 2 файл | 90% |
| 7 | | 11. Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлнэ. | 2021 - 2024 | | Эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах санал боловсруулж шийдвэрлүүлнэ. | Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр дараах дүрэм журмыг боловсруулж Барилга, хот байгуулалтын сайд болон Соёлын сайдаар хамтарсан тушаалаар батлуулах тухай 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1/5105 тоот албан бичгийг Соёлын сайдад хүргүүлсэн. Үүнд: - Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журам; - Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ; - Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар, үйл ажиллагааны журам. Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийг хэрэгжүүлж Улсын хэмжээнд хүчитгэх шаардлагатай барилга байгууламжийн судалгааг гаргасан. Улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан нийт 354 барилга, архитектурын дурсгал байгаагаас нийслэлийн хэмжээнд түүх соёлын дурсгалт Богд хааны ордон музей, Чойжин дагнины ордон музей, Улсын драмын эрдмийн театр, Дуурь бүжгийн эрдмийн театр нийт 4 барилга байгууламжийг паспортжуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 2. Олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ. | 2021 - 2025 | | Гадаадын их дээд сургуульд 10-аас доошгүй оюутан, дотоодод 150-аас доошгүй соёлын ажилтныг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна. Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх институтын барилгын зураг төслийг боловсруулсан байна. | Соёлын яамнаас ирүүлсэн саналын дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 32 дугаар тушаалаар, "Соёлын төвийн нэг маягийн зураг төсөл /Улсын хэмжээнд/" /200, 400 суудалтай/-ийг боловсруулах ажил дууссан, магадлал хийгдэж байна. "Монголын үндэсний археологи, угсаатны зүйн музейн зураг төсөл /Төв, Зуунмод/" төсөл арга хэмжээний хөрөнгийг баталж, гүйцэтгэгч сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан ба зөвлөх үйлчилгээний ажил хийгдэж дуусган Соёлын яаманд хүлээлгэж өгсөн болно.<br><br>Хавсралт : 1 файл | 90% |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 9 | 3.5.7. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн орон нутагт хэрэгжүүлэх иргэний болон үйлдвэрлэлийн барилга байгууламжийн томоохон төслийн эрчим хүчний эх үүсвэр, шугам | 1. Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ | 2021 - 2024 | | Төслийн урьдчилсан судалгааны санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. | Барилга, хот байгуулалтын сайдын баагцад батлагдсан ТЭЗҮ, зураг төслийн хөрөнгөөс 2021 онд 2,5 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлэн, холбогдох яамдаар зургийн даалгаврыг батлуулж, ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Мон энержи консалт” ХХК шалгаран гэрээ байгуулан, ажил хийгдэж байна. Үүний дагуу 2022 оны төсвийн тухай хуулиар эхний ээлжийн инженерийн шугам. сүлжээнд нийт 33.0 тэрбум, үүнээс 4.0 тэрбум төгрөгийг 2022 онд санхүүжүүлэхээр батлагдсан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 10 | | 2. Олон улсын нисэх | 2020 - | | Инженерийн | 1. БХБС-ын 2020/46 дугаар бүхий “Олон улсын нисэх онгоцны Чингис | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сүлжээ, дэд бүтцийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хийнэ. /Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ./ | онгоцны буудал, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлж, зураг төслийг хийнэ. | 2024 | | дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлно. | хаан буудлыг түшиглэн бий болох Богд хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлох зураг төсөл боловсруулах” ажлын даалгаврын хүрээнд сонгон шалгаруулалт явуулж, гүйцэтгэгчээр нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ шалгарч, 2021 оны 2021/44 тоот гэрээ байгуулан, 70%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. 2. Монгол Улсын 2021 оны төсвийн хүрээнд БХБ-ын Сайдын багцын 200 сая төгрөгийн санхүүжилтээр Хөшигийн хөндийн 1:5000 масштабтай байр зүйн зургийг боловсруулж дуусган хүлээн авсан. 3. ЭХС-ын 2021 оны А/103 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулсан. БХБЯ-ны ТНБ-ийн даргын 2021 оны А/29, 2021 оны А/52 тоот тушаалаар “Улаанбаатар хотын шинэ дагуул хотуудыг түшиглэн баригдах дулаан, цахилгааны 5 дахь эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах” ажлын гүйцэтгэгчээр “Мон энержи консалт” ХХК шалгаран гэрээ байгуулсан. 4.ЗТХС, БХБС-ын 2021 оны А/64, 98 тоот хамтарсан тушаалаар ажлын хэсгийг байгуулан, ажиллаж байна. 5.БХБ-ын сайдын 2021 оны 79 дүгээр тушаалаар Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилтийг баталсан. БХБЯ-ны ТНБ даргын 2021 оны А/107 дугаар тушаалаар байгуулж, Шинэ Зуунмодын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажлын 2021/71 дугаар, ус хангамжийн 2021/73 дугаар, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн 2021/72 дугаар, харилцаа холбооны 2021/70 дугаар даалгаврыг боловсруулж батлуулан, зөвлөхийн гүйцэтгэгчээр "Хайдродизайн Прожект" ХХК, "Престиж инженеринг" ХХК, "Наран рашаан" ХХК, "Оргил төсөл" ХХК, “Инженер геодези” ХХК-ийн түншлэл, "Анга транс" ХХК-иуд тус тус шалгаран ажлыг эхлүүлээд байна.<br><br>Хавсралт : 2 файл | |
| 11 | 3.7.1. Газрын харилцаа, хот байгуулалтын | 1. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын | 2020 - 2022 | | Хуулийн төслүүдийг Засгийн газраар | Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Хууль зүй дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдтай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 14-ны | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтооно. | төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барина. Үүнд: - Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; - Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; - Кадастрын зураглал ба газрын кадастрын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; - Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл; - Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | | | хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн барьсан байна | өдөр баталсан. Газрын багц хуулийн төсөлд Засгийн газрын гишүүд болон УУХҮЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, ЗТХЯ, ЭХЯ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ГЗБА, мэргэжилтэн, салбарын төрийн бус байгууллагууд, холбогдох ТББ, холбоод, олон нийтийн саналыг авах ажлыг албан бичгээр болон цахимаар, биечлэн хэлэлцүүлгийг зохион байгуулж ирүүлсэн саналыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан боловсруулсан. Газрын багц хуулийн төслийг Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөл болон Газрын шинэтгэлийн үндэсний хорооны хурлаар 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцүүлж хуулийн төслүүдийг дэмжиж, Газрын багц хуулийн төслийг өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар Хууль зүй, дотоор хэргийн сайд, Сангийн сайдад 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/5096 тоот бичгээр хүргүүлсэн. Хавсралт : 6 файл | |
| 12 | | 2. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барина. | 2020 - 2022 | | Хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлсэн байна. | 1.Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг ХЗДХС, БХБС-тай хамтран баталсан. Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1234 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн тусгасан. 2. Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7, 20.8 дахь хэсэгт заасны дагуу Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаас уг хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулж байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт : 7 файл | |
| 13 | | 3. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барина. | 2020 - 2022 | | Хуулийн төслийг Засгийн газраар хэлэлцүүлж, Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан байна | БХБ-ын сайдын 2021 оны 06 дугаар сарын 02-ны 127 дугаар тушаалаар Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тхуай анхдагч хуулийн төслийг боловсруулах үүрэг ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан. Ажлын хэсгээс Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийг 5 бүлэг, 20 зүйлтэй байхаар боловсруулж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааны тайлан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн. Олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах ажлын хүрээнд тус яамны Цахим хуудас https://mcud.gov.mn/forum/21 -т уг хуулийн төслийг холбогдох материалуудыг хамт 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс байршуулж санал авч, мөн 21 аймгийн ГХБХБГ-аас ирсэн саналуудыг тусган нэгтгэж Засгийн газрын гишүүдээс санал авхаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.<br><br>Хавсралт : 3 файл | 50% |
| 14 | | 4. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна. | 2020 - 2022 | | Улсын Их Хурлаар хэлэлцэж баталсан байна. | Хот байгуулалтын тухай хуулийн шинэчлсэн найруулгын төслийг 2020.01.22-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын ЭЗБХ-ны 2020.11.04-ний өдрийн, УИХ-ын нэгдсэн чуулганы 2020.11.06-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн гишүүдийн 82 хувийн саналаар уг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, УИХ-ын ЭЗБХ-нд шилжүүлсэн. УИХ-ын ЭЗБХ-оос Хуулийн төслийг УИХ-ын 2021 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулсан. УИХ-аар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. http://forum.parliament.mn/projects/10785<br><br>Хавсралт : 1 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | | 5. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна. | 2020 - 2022 | 9.0 сая төгрөг, Нором, нормативын сангийн хөрөнгө | Улсын Их Хурлаар хэлэлцэж баталсан байна. | ЗГХЭГ-ын 2019.12.02-ны ЗГ-1/184 тоот албан бичгээр "Орон сууцны тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан. УИХ-ын 2020.10.08-ны 28-р тогтоолоор баталсан Хууль санаачлагчид нь буцаах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт"-ын 20-д "Орон сууцны тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөл багтсан. Иймээс уг хуулийн төслийг шинэчлэн дахин боловсруулах шаардлагатай болсон тул уг төслийн Үзэл баримтлалын төсөл боловсруулах "Ажлын хэсэг"-ийг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021.04.09-ний А/57 дугаар тушаалаар байгуулж, Ажлын хэсгийн төлөвлөгөө батлуулсан. Ажлын хэсэг 2021.08.26-наас 2021.09.29-нийг хүртэлх хугацаанд болон 2021.11.18-ны өдрүүдэд Төр, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагын төлөөллүүд оролцсон нийт 9 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн зөвлөх "Монголын эрх зүйн орчны хөгжлийн холбоо" ТББ-тай 2021/366 тоот гэрээг 2021.10.22-нд байгуулан, үзэл баримтлалын төсөлд 18 байгууллагын саналыг тусган батлуулахаар 2021.12.02-ны 1/4831 тоот албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд хамтран батласан..<br><br>Хавсралт : 1 файл | 50% |
| 16 | | 6. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барина. | 2020 - 2022 | | - | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 80 заалт нь хэрэгжиж үлдсэн 108 заалтын 40 гаруй хувь нь хэрэгжилт хангалтгүй байгаа тул нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажил 2017 оноос хойш хийгдэн, үзэл баримтлалын төслийг батлуулан, хуулийн төслийг эцэслэн боловсруулж, 2021.07.05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. Хуулийн төслийг хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 17 | 3.7.2. "Цахим Монгол" арга | 3. Батлан хамгаалах, газар зохион | 2020 - 2024 | | 1914 хуудас байр зүйн зураг | Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг 2021 оны улсын төсөвт тусгуулахаар СЯ-нд хүргүүлсэн боловч, их хэмжээний санхүүжилт | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний хүрээнд олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно. | байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам,төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна. | | | хийнэ. | шаардлагатайгаас шалтгаалан 2016 оноос хойс хасагдаж байна. Иймд бусад боломжит эх үүсвэрийг судлан дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн МН-ТГ/08 тоот албан бичгээр “Геодези, зураг зүйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээр”-ийн төслийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн, Оросын талтай хэлэлцэн тохиролцох, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд болон Засгийн газарт танилцуулах бэлтгэл ажлыг хангах чиглэлийг Барилга, хот байгуулалтын сайдад өгсөн. Үүний дагуу тус яамнаас ОХУ-ын холбогдох байгууллагатай зөвшилцөж /эцсийн төслийг 2021.11.10-ны өдөр тус яаманд ирүүлсэн/, Монгол Улсын Гадаад харилцааны яамаар хянуулж, хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийн хамт боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын гишүүд болон Тагнуулын Ерөнхий газраас санал авах ажлыг зохион байгуулж 2021.11.25-ны өдрийн МН/107 тоот маш нууцын зэрэглэлтэй албан бичгээр хүргүүлсэн /2021.12.15-ны байдлаар ХЗДХЯ, ХНХЯ-аас бусад нь саналаа ирүүлээд байна/. 2. Ирүүлсэн саналыг нэгтгэн Хэлэлцээрийн төслийг эцэслэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар бэлтгээд байна.. /Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу энэхүү арга хэмжээн нь нууцын зэрэглэлтэй тул файл хавсаргах боломжгүй/ | |
| 18 | | 5. Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2020 - 2021 | | Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 29 дүгээр тушаалаар дээрх төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт шилжүүлсэн. Үүний дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Геомастер” ХХК-тай 2020/85 тоот гэрээг байгуулан, гүйцэтгэлийн явцад “Топ сүрвэй” ХХК захиалагчийн техникийн хяналтыг хийсэн. “Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулах” зөвлөх үйлчилгээ /1-3 дугаар багц/-ний 2020/85 дугаартай гэрээт ажлын ажлыг ГЗБГЗЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 2020/85-04 тоот дүгнэлт, гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг Архив мэдээллийн төвд хүлээн авсан тухай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2021/ГБЗЗ/48 дугаартай актаар эцсийн шатны гүйцэтгэлийг хүлээн авч, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлсэн. Тус системийг хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авах ажлыг зохион байгуулж байна. Хаягийн мэдээллийн санд нийт 1,081186 нэгж талбар, 689895 барилга байгууламж, 49826 гудамжны өгөгдлийг оруулсан. Эдгээр өгөгдөлд автоматаар хаяг олгох боломжтой "Хаягийн мэдээллийн систем"-ийг хөгжүүлж, улсын хэмжээнд хот суурин газрын 650489 нэгж талбар, 283995 барилгыг хаягжуулаад байна. Мөн нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 10071 гэр хорооллын гудамж, 280332 хашаа, 89188 байшинг Хаягжуулалтын тухай хууль, журмын дагуу дугаарлаж, хаяг нэр өгч, хаягийн зураг зохион, мэдээллийн санг үүсгэсэн. Мөн Монгол Улсын 1:100000 масштабтай газар усны нэрийн тоон зургийн 258650 газар, усны нэрийн өгөгдлийг хаягийн мэдээллийн санд бүртгэж, малчдын өвөлжөө, хаваржаа, газар тариалангийн зориулалтаар ашиглаж байгаа нийт 206511 нэгж талбарт газар усны нэрийн дагуу шинээр хаяг олгоод байна. /Нууцын зэрэглэлтэй тул файл хавсаргах боломжгүй./ | |
| 19 | | 6. Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ. | 2020 - 2024 | 99.0 сая.төг, Орон нутгийн төсвийн хөрөнгө | Газар зүйн нэрийн тодруулалт хийсэн байна. | 1. "Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт" MNS 6925-1-18: 2021" Монгол Улсын стандартыг Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 сарын 09-ны өдрийн С/36 тушаалаар MNS 6925-1-18:2021 үндэсний стандарт болгон батлуулсан. 2. Нийслэл болон 21 аймгийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд геодези, зураг зүйн чиглэлээр хамтарч ажиллах чиглэлд газар зүйн нэрийг тодруулах арга хэмжээг тусгаж, дараах ажлын даалгавруудыг шинээр болон шинэчлэн баталсан. Үүнд: • Өвөрхангай аймаг, Хайрхандулаан сум- АД/2021-11; • Дорнод аймаг, Цагаан-Овоо, Сэргэлэн сум –АД/2021-08; • Дорнод аймаг, Баян-Уул сум - АД/2021-17 • Сүхбаатар аймаг, 13 сум – АД/2021-37. Даалгаварын дагуу 2021 онд газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг Өвөрхангай аймаг, 1 суманд 9 сая төгрөг, Дорнод аймаг, 2 суманд 20 сая, Сүхбаатар аймаг 7 суманд 70 сая төгрөг, нийт 3 аймгийн 10 суманд 99 сая төгрөгийн ажлыг зохион байгуулсан. 3. Газар зүйн нэрийн тодруулалтын 2020 онд зохион байгуулагдсан Дорнод аймгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 сум, 2021/27 дугаартай дүгнэлт, Булган аймгийн 3 сумын 2021/40 дугаартай дүгнэлт, Дундговь аймгийн 2 сумын 2021/41 дугаартай дүгнэлт, Дорнод аймгийн 1 сумын 2021/42 дугаартай дүгнэлт, Хэнтий аймгийн 1 сумын 2021/43 дугаартай дүгнэлт, нийт 8 сумын 5 дүгнэлтийг ГЗБГЗЗГ-ын дэргэд байгуулагдсан Газар зүйн нэрийн зөвлөлийн 2021 оны 03 дугаар хуралд танилцуулж, Архив, мэдээллийн төвд хүлээн авсан.<br><br>Хавсралт : 3 файл | |
| 20 | 3.7.3. Хиймэл оюун ухаан болон блокчейн, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангасан технологид суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | 4. Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2021 - 2024 | | Техник эдийн засгийн үндэслэл боловсруулна. | Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлэх ТЭЗҮ-ийн төсөл боловсруулж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зарим нэмэлт асуудлуудыг тусгуулахаар буцаасан. ТЭЗҮ-ийн төсөлд холбогдох саналыг тусган Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлэх ТЭЗҮ төслийг эцэслэн боловсруулж, 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 21 | | 5. Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно. | 2021 - 2023 | | Зураг төсөв боловсруулна. | Газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулах ажлын газрын асуудал шийдэгдсэн. Тус ажлын ТЭЗҮ-г боловсруулах ажлын урьдчилсан судалгааг хийх ажлыг зохион байгуулж, мөн тус ажлын зураг төсөл боловсруулах ажлын зардлын тооцоог судалж байна. Уг газрын биржийн удирдлагын нэгдсэн төв /Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын төв офиссын барилга/ байгуулах болон газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгох ажлын зураг эскизийн түвшинд хийгдсэн. Төсөл боловсруулах төсөв батлагдаагүй тул энэ ажил хойшлогдсон.<br><br>Хавсралт нийт : 5 Файл : 3 Зураг : 2 | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | | 7. Улсын хэмжээнд ашиглагдаж буй барилга, байгууламжийн паспортжуулалт, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулна. | 2021 - 2024 | 70 сая төгрөг, Улсын төсөв | Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг аймаг, нийслэлд үргэлжлүүлэн хийнэ. /200 барилга/ | -Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн боловсруулахаар аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авч журмын төслийг боловсруулан, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн хурлаар төслийг хэлэлцүүлж, Шадар сайдын 2021 оны 2 дугаар тушаалаар Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн баталсан. -Монгол Улсын 2021 оны төсөвт паспортжуулалтын ажлын 70 сая төгрөг тусгагдсаны дагуу нийслэлийн хэмжээнд нийт 89 барилга байгууламжийн суурь судалгаа, байгууламжид биет үзлэгийн судалгааг үе шаттайгаар хийж паспортжуулаад байна. -Нийслэлд 2021 оны байдлаар орон сууцны 617, төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт олон нийтийн 163, нийт-780 барилгад буюу 42.5 хувьд нь хэмжилт, судалгаа хийж, дүгнэлт гаргаж, паспортжуулсан. Барилга байгууламжид хэмжилт, судалгаа хийх, паспортжуулах ажил болон багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажилд нийт 2.3 тэрбум төгрөг зарцуулсан. Уг тулгамдаад буй асуудлыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Барилга байгууламжийг паспортжуулах ажилд шаардлагатай санхүүжилтийг 2021 оны Улсын төсөвт тусгах саналаа 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2671 тоот албан бичиг, 2022 оны Улсын төсөвт тусгах саналаа 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй. 2022 оны Нийслэлийн төсөвт барилга байгууламжийг паспортжуулах ажилд 560 сая төгрөг туссан байна.<br><br>Хавсралт : 4 файл | 70% |
| 23 | | 8. Аймаг, сум, суурин газруудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар | 2021 - 2023 | 399 сая төгрөг | Үлдсэн 9 аймгийн судалгааны ажлыг эхлүүлнэ. | Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил”-ын хүрээнд Одон орон, геофизикийн хүрээлэнтэй 2018 оны 8 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажлын хийж дуусган, мэдээллийн нэгдсэн санд оруулна. | | | | дугаар сарын 21-ний өдрийн 2018/175 дугаартай зөвлөх гэрээг байгуулсан ажиллаж байгаа ба 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл”-ийн хуралд дээрх ажлын санхүүжилтийг яаралтай шийдвэрлэх саналыг танилцуулсан. Үүний дагуу Шадар сайдаас Сангийн яаманд санхүүжилтийг шийдвэрлэх талаар үүрэг даалгаврыг өгч эхний ээлжинд Хөвсгөл, Өмнөговь, Увс аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын судалгааг хийхийг даалгасан. Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилтийг 2021 оны төсвийн төсөлд тусгах саналаа 2020 оны 08 дугаар сарын 14-ний 01/2671 тоот, 2022 оны төсвийн төсөлд тусгах саналаа 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгээр Сангийн яаманд тухай бүрт хүргүүлсэн боловч одоог хүртэл ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх санхүүжилт шийдэгдээгүйн улмаас зөвлөх үйлчилгээний гэрээт ажил зогсоод байна. Уг асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр танилцуулсан. Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 9 аймгийн газар хөдлөлийн бичил мужлалын зургийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлэхэд дэмжлэг хүсэх тухай 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/4889 тоот албан бичгийг хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Үүний дагуу Засгийн газрын 2021 оны 58 дугаар тэмдэглэлийн 7-т “дээрх 9 аймгийн төвүүдийн нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг зохиох арга хэмжээ авахыг Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэлд” даалгасан.<br><br>Хавсралт : 5 файл | |
| 24 | 3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн | 1. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулж, батлуулан | 2020 - 2022 | | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг | 1.“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” /ХАНСХЕТ/ боловсруулах арга зүйг боловсруулж, ХАНСХЕТ-ний ажлын явцын танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2021.03.15-ны өдөр 1/917 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 18 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан. Тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно. | хэрэгжилтийг хангана. | | | боловсруулна. | хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ХБТТУТ хууль болон Хот байгуулалтын тухай хуулиудын хэрэгжилтийн уялдааг хангах, ”Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын баримт бичгүүдийг боловсруулах үйл ажиллагааг харилцан уялдуулж, зохицуулах үүрэг бүхийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг боловсруулан БХБС-ын 2021.06.02-ны өдрийн 126 дугаар тушаалаар баталж, ҮХГ-т 2021.06.02-ны өдрийн 3/2068 тоот албан бичгээр хүргүүлсэн. ҮХГ-тай хамтарсан уулзалтыг 2021.10.20, 11.1-2-ний өдрүүдэд 3 удаа зохион байгуулж, эдийн засгийн бүс, бүлэг сууринг ийн тогтолцоо, хүн амын хэтийн тооцоо зэрэг асуудлуудыг харилцан уялдаатай төлөвлөсөн. 2.“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг батлах тухай” УИХ-ын тогтоол, үзэл баримтлалын төслийг боловсруулж, Зөвлөх баг болон Барилгын хөгжлийн төвд цахимаар хүргүүлж, холбогдох саналыг авсан 3. ХАНСХЕТ-ийг боловсруулах 2018/199, 2020/249 дугаартай гэрээнүүдэд эхлэлийн, дундын, эцсийн нийт 7 тайлан ирүүлэхээр тусгаснаас эхлэлийн 2, дунд шатны 2, “Хүн амын өсөлт, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн дэд бүтэц”, “Аж үйлдвэр дэд бүтэц”, “Хүн амын нутагшилт, суурьшил” зэрэг 3 боть ХАНСХЕТ-ийн эцсийн тайланг боловсруулж дуусаад байна.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 25 | | 3. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2020 - 2024 | | Холбогдох яамдтай хамтран хэрэгжүүлж, тайланг ЗГ-т хүргүүлнэ. | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр нийт 11 зорилт, 86 арга хэмжээ, 526 бүтээгдэхүүн байхаар төлөвлөж, уг төлөвлөгөөний хэрэгжилт 2020 оны байдлаар 58.3 хувьтай байна. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2020 оны байдлаар тодорхой үр дүнд хүрсэн байна. Засгийн газрын тогтоолын дагуу Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтийг бүх яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга нараас биелэлтийг авч нэгтгэн, Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 24 дүгээр тэмдэглэл гарсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт : 1 файл | |
| 26 | | 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн, зураг төслийг боловсруулах ажлыг үе шаттай зохион байгуулна. | 2021 - 2024 | | Төсөл, арга хэмжээний эрэмбийг тогтоож, зураг төслийг үе шаттай боловсруулна. | Барилга,хот байгуулалтын сайдын 2021 оны 32, 66, 83, 101,179 дүгээр тушаалуудаар нийт 148 төсөл, арга хэмжээний жагсаалт батлагдсан. Үүнд: - 136 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдсан, 10 төсөл, арга хэмжээ тендерийн шатанд, 2 төсөл, арга хэмжээ үнэлгээний шатанд тус тус байна. Гэрээ байгулагдан хэрэгжиж буй 136 зураг төсвийн ажлын хувьд 100 хувь дуусч хүлээлгэн өгсөн 57 ажил ба үлдсэн 79 төсөл, арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу 2022 онд дамжин хэрэгжиж байна. | 100% |
| 27 | 3.7.5. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна. | 1. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. | 2020 - 2024 | | - | 1.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" болон "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", Японы Олон улсын хамтын ажиллагааны ЖАИКА байгууллагын техник туслалцааны хүрээнд боловсруулж буй "Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө" төслийн хүрээнд Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн судалгааг хийж, урьдчилсан байдлаар санал боловсруулсан. 2. Тус саналыг хэлэлцүүлэхээр зохион байгуулсан 2021.04.15-ны өдрийн цахим хэлэлцүүлэгт дээрх 3 төслийн хүрээнд хийгдсэн судалгаа, төлөвлөлтийн шийдэл боловсруулах явцад Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн төлөвлөлтийн шийдлийн саналыг тус тус хэлэлцүүлсэн. Уг хэлэлцүүлгээр "Нийслэл хотын чиг үүргийг шилжүүлэх" асуудал дээр санал авч, БХБ-ын сайдын 2019 оны 31 дүгээр тушаалаар байгуулсан Зөвлөх багийн гишүүдийн олонхийн саналаар нийслэлийн зарим чиг үүргийг нутаг дэвсгэрийн төв хэсэг Орхоны хөндий буюу Хархоринд шилжүүлэх боломжийг судлах нь зүйтэй гэж үзсэн. Уг саналын дагуу "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн хүрээнд тус асуудлаар судалгаа хийж санал боловсруулан тусгаж байна. 3. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах саналыг БХБЯ-ны 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгийг СЯ-нд хүргүүлсний дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | БХБС-ын багцад нийт 1.3 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлсэнээс 2022 онд 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг тусгуулаад байна.<br><br>Хавсралт : 7 файл | |
| 28 | 3.7.6. Цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна. | 2. "Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын систем, хагас нэвтрэх сувагт төлөвлөх, шинээр барьж байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020 - 2024 | | Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана. | УИХ-ын 2020 оны 55-р тогтоолоор “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг байгуулахдаа Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө холбогдох баримт бичигтэй уялдуулан үе шаттайгаар шийдвэрлэхийг даалгасан. Үүнд: 1.“Шинэ Зуунмод” хотод байрлах Олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн хангамжийн судалгаа, эх үүсвэрийн тодорхойлох зураг төсөл боловсруулах ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. 2.БХБ-ын сайдын 2021 оны 79 дүгээр тушаалаар Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах төсвийг батлуулсан. Зөвлөх үйлчилгээний 5 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зураг төсөл боловсруулах гэрээг байгуулан ажлыг эхлүүлээд байна. 3.Инженерийн шугам сүлжээг хонгилын системд төлөвлөх "ХОНГИЛЫН СИСТЕМ" /БД/-ийн төслийг 2021 оны 10 дугаар сард урьдчилсан байдлаар боловсруулж дуусган МХЕГ, ШУТИС болон “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ зэрэг 19 байгууллагад санал авахаар хүргүүлээд байна. Мөн https://mcis.gov.mn/main/norm цахим хуудсанд байршуулж санал авч боловсруулалт хийж байна. Барилгын дүрмийн төсөлд саналуудыг тусгаж 2022 оны эхний хагас жилд багтаан яамны ШУТТЗ-ийн хуралд оруулж хэлэлцүүлээхээр ажиллаж байна.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 29 | 3.7.7. "Шинэ Зуунмод", "Майдар" шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг | 1. "Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох | 2020 - 2024 | | Холбогдох тооцоо, судалгаа хийнэ. | Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр, Хөшигийн хөндийд “Чингис хаан” буудлыг даган шинээр байгуулах “Шинэ Зуунмод”, “Майдар” хотууд, Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хот, босоо тэнхлэгийн ОУ-ын хурдны АН-3 автозам, “Богдхан төмөр зам” тэдгээрийг даган бий болох чөлөөт бүс, тээвэр логистикийн нэгдсэн төв, инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг цогцоор | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. | судалгаа хийж, шийдвэрлүүлнэ. | | | | хэрэгжүүлэх орон зайн нэгдсэн төлөвлөлтийн асуудлыг БХБ-ын сайд Засгийн газрын 2021. 3.24-ний өдрийн хуралдаанд танилцуулж,19 дүгээр тэмдэглэл гарсан. БХБ-ын сайд Б.Мөнхбаатар шинээр байгуулах "Шинэ Зуунмод", "Майдар" хотуудын төлөвлөлтийн нэгдсэн концепцийг 2021.06.10-ны өдөр Төвийн амйгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр, Хөшигийн хөндийд газар дээр нь очиж МУ-ын Ерөнхий сайдад танилцуулсан. “Шинэ зуунмод”, “Майдар” хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох санал боловсруулах, холбогдох тооцоо судалгааг хийх үүрэг бүхий ажлын хэсгийг БХБЯ-ны ТНБД-ын 2021 оны а/138 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Мөн ЗТХ-ийн сайд, БХБ-ын сайдын 2021.04.29-ний өдрийн А/64, 98 тоот хамтарсан тушаалаар салбар хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд хамтарч ажиллах чиг үүрэг бүхий АХ-г байгуулан ажиллаж байна. Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд шинэ хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох судалгааны ажилд шаардагдах зардлыг тусгуулах саналыг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 30 | | 2. "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020 - 2024 | | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулна. | “Шинэ зуун мод” хотын ерөнхий төлөвлөгөөг холбогдох төслүүдтэй орон зайн хувьд нэгдсэн цогц төлөвлөлтийн концепцийг боловсруулах чиглэл өгөгдсөн. Үүний дагуу “Некст степ инженеринг” ХХК, нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын боловсруулж буй төлөвлөлт, судалгааны ажлуудыг боловсруулах ажлын хүрээнд: 1. Хөшигийн хөндий бүс орчмын нэгдсэн төлөвлөлт болон орон сууц, олон нийтийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Некст степ инженеринг ХХК боловсруулахаар ажлын даалгаварт холбогдох өөрчлөлтийг оруулж БХБС, ЗТХС нар хамтран 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 2021/87 дугаартай баталсан; 2.Тус бүс нутгийн логистикийн нэгдсэн төвийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтцийн нэгдсэн эх үүсвэрийн судалгаа, зураг төсөл, нэгдсэн төлөвлөлтийн концепцийн дагуу биет загвар (макет)-ыг тус тус боловсруулахтай холбогдуулан ажлын даалгаварт зохих өөрчлөлтүүдийг оруулж БХБС-ын 2021.10.20-ний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн 2021/80, 2021/81 дугаартай батлуулсан. Зуунмод”, “Майдар хот”, Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотуудыг харилцан уялдаатай хөгжүүлэх, дэд бүтцийг цогцоор шийдвэрлэн олон улсын жишигт хүрсэн эдийн засгийн хөгжлийн шинэ бүс байгуулах нь зүйтэй гэж үзэн Төв аймгийн Хөшигийн хөндий дэх шинэ хотуудын нэгдсэн төлөвлөлтийн /концепци/-ийг Олон улсын нисэх онгоцны “Чингис хаан” шинэ буудлыг түшиглэн бий болох Богд хаан төмөр зам, авто замын /АН-3/ хурдны зам, “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал”-тай уялдуулан боловсруулж ЗГ хуралдаанд 2021 оны 6-р сарын 30-ны өдөр танилцуулж, 38 дугаар тэмдэглэл гарсан. Төв аймгийн Хөшигийн хөндий дэх бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Төв аймгийн Хөшигийн хөндий дэх бүтээн байгуулалтын асуудлыг хариуцсан захиргаа байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж ЗГ-ын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, 234 дүгээр тогтоол гарсан.<br><br>Хавсралт : 5 файл | |
| 31 | | 3. "Майдар" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээг боловсруулсан байна. | Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний баримт бичиг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК 2020/69 тоот гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа бөгөөд тус компаниас эхлэлийн болон дундын шатны тайланг боловсруулж захиалагчийн хяналт хийгдсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 137 дугаар тушаалаар тус ажилд магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах орон тооны бус экспертүүдийг томилж, магадлалын нэгдсэн дүгнэлт 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 709/2021 дугаартай гарсан. ГЗБГЗЗГ-аас 2021.11.24-ний өдрийн 2/2285 тоот албан бичгээр эцсийн шатны тайланд захиалагчийн хяналт хийсэн ЗХТ/ТХТ-3 дугаартай дүгнэлтийг ирүүлсэн. МАЭ-ийн даргадэх “Архитектр, хот төлөвлөлтийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021.04,15-ны өдөр хэлэлцүүлсэн, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-аар 2021.12.21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | 3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ. | 1. Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна. | 2020 - 2024 | | Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | “Үндэсний Орон сууцны корпораци” ТӨХХК-ийн бүтэц, орон тоо, дүрмийн төслийг боловсруулж Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Үүнтэй холбогдуулан “Нийслэлийн Орон сууцны корпораци” ХК-ийн ТУЗ-өөс Компанийн тухай хуулийн дагуу “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-тай нэгдэх асуудлыг НИТХ-ын 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар хэлэлцэж, нэгтгэх асуудал дэмжигдээгүй тул “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2022-2026 оны стратеги бүтцийн өөрчлөлтийг хийж, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор баталсанаар Үндэсний орон сууцны корпорацийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК ийн чиг үүрэг нэмэгдэж байгаатай холбогдуулан БХБЯ-аас Дэлхийн банкны зөвлөх үйлчилгээгээр чадавх бэхжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 33 | 3.7.9. Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе | 1. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2021 - 2024 | | Төслийн хэрэгжилт 30 хувьд хүрнэ. | Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд тус төслийн хүрээнд байгуулагдсан гэрээ хэлэлцээрийн дагуу Монголын тал хүлээсэн зураг, төсөл, газар чөлөөлөлт, инженерийн дэд бүтцийн ажлууд бүрэн хийгдэж дууссан. Төслийн Ерөнхий гүйцэтгэгч БНХАУ-ын “Хоёр дахь Металлурги групп корпораци” ХХК-тай 2020 оны 12 дугаар сарын 11-нд гэрээ байгуулсан гэрээнд Барилга эхлэх хугацааг 2021 оны 4 сарын 25 гэж заасан бөгөөд батлагдсан хуваарийн дагуу 2021 оны 02 дугаар сарын 25-наас эхлэн удирдлагын багийн 9 гишүүн, инженер техникийн 35 ажилчид Монгол улсад үе шаттайгаар орж ирэх ёстой байсан боловч Монгол улсад Ковид цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан БНХАУ-ын Худалдааны яамнаас Хятад ажилчдыг хилээр нэвтрэх зөвшөөрөл өгөхгүй байгаа тул өнөөдрийг хүртэл Монгол Улсад ирж чадахгүй байгаа ба барилга угсралтын ажил эхлэх хугацаа мөн хойшлоод байна. Тус асуудалтай холбогдуулан Ерөнхий гүйцэтгэгч компаниас Барилга, хот байгуулалтын яаманд 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн албан бичгээр гэрээний дагуу барилгын ажил эхлэх хугацааг “Протокол-д заасан давагдашгүй хүчин | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаттай эхлүүлнэ. | | | | | зүйлийн улмаас хойшлуулах хүсэлтийг ирүүлсэн. Ногоон гарц түр ашиглах журмын дагуу БНХАУ-аас 2022 оны 2 дугаар сард голлох ИТА нарыг оруулж ирэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Нийт төслийн хэрэгжилт төлөвлөгөөний дагуу 20 хувьд хүрсэн.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 34 | | 2. "Солонго 1", "Солонго 2" төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2020 - 2024 | 7,677.1 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламж | Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төслийг эхлүүлнэ. | БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн зөвлөх үйлчилгээний хуулийн этгээд болох SAMOO JV-тай нийт 6 удаагийн гэрээний хэлэлцээрийг зохион байгуулж, гэрээний төслийг БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан болон Экспорт-Импортын банкны жишиг гэрээний төсөлд тулгуурлан боловсруулж, банкинд гэрээ байгуулах зөвшөөрөл авах хүсэлтийг 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 03/1469 дугаар албан бичгээр хүргүүлсэн. БНСУ-ын Экспорт-Импортын банкнаас 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн MON-221/859 дугаар албан бичгээр гэрээ байгуулах зөвшөөрөл ирүүлсэний дагуу 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн MCUD-2020/SAHP-CS-01 дугаартай гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан. Зөвлөх үйлчилгээний гэрээнд банкнаас сүүлийн зөвшөөрлийг авахаар холбогдох маягтын хамт 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 03/1538 дугаар албан бичгээр хүргүүлж, банкнаас 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зөвшөөрлийг ирүүлсний дагуу гэрээ албан ёсоор хүчин төгөлдөр болж, зураг төслийн ажил эхэлсэн. Төслийн хэрэгжилт, хяналт, удирдлагын тогтолцоог хангах хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 116 дугаар тушаалаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-г төсөл хэрэгжүүлэх нэгжээр томилсон. Мөн төсөлтэй холбоотой бүхий л түвшний зураг төслийн ажлуудад дүгнэлт өгөх, тухай бүр мэргэжлийн түвшинд хянуулах, хэлэлцүүлэх, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг сайдын 2021 оны 153 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Төслийн Эскиз зураг боловсруулагдаж 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраар батлагдсан бөгөөд цаашид гэрээний дагуу 2022 оны 1 дүгээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улиралд багтаан зураг төслийн ажлыг дуусгаж, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг эхлүүлэх ба 2022 оны 2 дугаар улиралд багтаан төслийн барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.<br><br>Хавсралт : 4 файл | |
| 35 | | 3. "Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2020 - 2024 | | Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төслийг эхлүүлнэ. | Төслийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагч, зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ажлын сонгон шалгаруулалтыг БНСУ-ын Экспорт-Импортын банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулж, 2021 оны 09 дүгээр сард "АУМ ба Лий" консерциумтай гэрээ байгуулагдсан. Зөвлөх үйлчилгээний эхлэлтийн тайлан 12 дугаар сарын 8-ний өдөр авсан. Төлөвлөгөөний дагуу зураг төслийн ажлыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан боловсруулж, 3 дугаар улиралд барилга угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Нийт төслийн ажлын явц 15 хувьтай байна.<br><br>Хавсралт : 1 файл | 50% |
| 36 | | 4. Орлогод нийцсэн 10,000 орон сууцны эко хорооллын төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2020 - 2024 | | Төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлнэ. | Төслийн нарийвчилсан зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтууд хийгдэж дууссан бөгөөд шалгарсан зөвлөх компаниуд төслийн эхний ээлжийн орон сууцны хорооллын зураг төслийн ажил болон төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж 2022-ны 1-р улиралд дуусгахаар төлөвлөсөн. Энэ хүрээнд төслийн эхний ээлжийн 2 байршлын 164 нэгж талбарын 11.1 га талбайн нийт 265 өрхөд төслийн талаарх мэдээлэл хүргэж 2021.05.01-ний өдрөөс эхлэн төсөлд хамрагдах хүсэл сонирхлын судалгааг утсаар авсны үр дүнд үндэслэн нийгэм эдийн засгийн судалгааг хийж байна. Түр суурьшуулах 56 өрхийн орон сууцны архитектур төлөвлөлтийн дааалгаврыг 2021.04.09-ний Хот байгуулалт, хөгжлийн газрын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Мөн төслийн хүрээнд газар чөлөөх айлуудыг түр суурьшуулах орон сууцны инженерийн дэд бүтцийн техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | | | | | | Үүнд: -"Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ" ТӨХК-иас 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн № 21-99-000566 дугаар цахилгаан хангамжийн техникийн нөхцөл; -"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨК-иас 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн TH-D195/201 дугаар мэдээлэл холбооны техникийн нөхцөл; -Ус сувгийн удирдах газраас 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 130/21 дугаар ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл. | |
| 37 | | 5. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлнэ. | 2020 - 2024 | | Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлнэ. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар СХД-ийн 6 дугаар хороонд 712 айлын орон сууц барих төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг "Эм Эй Ди Урбан" ХХК /MAD Urban/-иар гүйцэтгүүлж, 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Төслийн хөрөнгө оруулалтыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг НиТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Мөн өрийн удирдлагын тухай хуулийн дагуу "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т дээрх төслийг оруулах талаар УИХ-ын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төсөл, үзэл баримтлалыг ЗГХЭГ-аас боловсруулан 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдөр яамдуудаас санал авч, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, УИХ-д өргөн барихаар тогтсон.<br><br>Хавсралт : 3 файл | 50% |
| 38 | | 6. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2020 - 2024 | | БНХАУ-ын 700.0 сая юаны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал боловсруулан, | Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хооронд 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан хэлэлцээрийн хөрөнгөөр "Улаанбаатар хотын гэр хорооллын инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийг сайжруулах" төслийг хэрэгжүүлэх саналыг 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 03/2343 албан тоотоор Сангийн яаманд уламжилж, Сангийн яамнаас мөн өдрийн 10/4156 албан тоотоор БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлсэн. БНХАУ-аас МУ-д суугаа ЭСЯ-ны зүгээс дээрх төслийн саналыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох газарт хүргүүлнэ. | Худалдааны яаманд уламжилсан бөгөөд тухайн үед гуравдагч үнэлгээний байгууллагад шилжүүлсэн байна. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Цай Веньруй-тай 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр барилга, хот байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон уулзалт хийсэн. Тухайн уулзалтаар тус төслийн хэрэгжилтийг урагшлуулах асуудлаар байр сууриа илэрхийлж, ЭСЯ-ын зүгээс дэмжиж ажиллахаа харилцан илэрхийлсэн. Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайд Т.Бадрал 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр БНХАУ-ын Орон сууц, хот-хөдөөгийн хөгжлийн сайд Ванг Менгхүйтэй хийсэн уулзалтын үеэр төслийн талаар санал солилцсон бөгөөд Ковид-19 нөхцөл байдалтай холбогдуулан төслийн явц удааширч байгаа талаар айлын талаас мэдээлсэн байна.<br><br>Хавсралт : 5 файл | |
| 39 | | 7. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30 000 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2020 - 2024 | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц барих газрын нэгдсэн мэдээлийн сан байгуулж, газрын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Монгол Улсын хэмжээнд 2020 онд ашиглалтад орсон болон 2023 он хүртэл баригдах орон сууцны төслүүдийн нарийвчилсан судалгааг /Үүнд: өрөөний тоо, гүйцэтгэлийн хувь, нэгж м.кв-ын үнэ, байршил болон бусад нарийн мэдээлэл орсон/ “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай хамтран 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр боловсруулсан. Судалгааны агуулга, мэдээллийн үнэн, зөв байдлыг сайжруулан цаашид тогтмол хийх, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллах хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03/1374 дугаар албан бичгээр холбогдох чиглэлийг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т хүргүүлсэн. Үүнтэй холбогдуулан өмнө нь хийсэн судалгааны үр дүнг сайжруулах, дахин мэдээллийн санг баяжуулах хүрээнд орон сууцны зах зээлийн судалгааг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ болон Барилга.мн хамтран 2021 оны 08 дугаар сард боловсруулсан. Судалгааны үр дүнтэй танилцаж, холбогдох тодруулга мэдээллийг авч, удирдлагыг тогтмол мэдээллээр хангаж ажиллав. Улсын хэмжээнд орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө эзэмшигчийн тоон мэдээллийг 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 3/1986 тоот албан бичгээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлэн гаргуулж авсан. Мөн улсын хэмжээнд 2019 оноос хойш ашиглалтад орж, үл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авсан амины орон сууцны тоон мэдээллийг 2021 оны хагас жилийн байдлаар уг газраас 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 3/3266 тоот албан бичгээр гаргуулан авч судалгаанд ашиглан ажиллав. Төр хувийн түншлэлийн хүрээнд Залуу гэр бүлийг орлогод нийцсэн орон сууцаар хангахаар тус яамнаас төслийн концепц, техникийн шийдлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Морингийн даваа орчмын “ТОСК” ТӨХХК-ийн 57 га талбайд “Залуус-1” орон сууцны хороолол барих төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. ТЭЗУС-ыг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Архитектор төлөвлөлтийн даалгавар 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, Эх загвар зураг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тус тус батлагдсан.<br><br>Хавсралт : 2 файл | |
| 40 | | 9. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны төслийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулна. | 2020 - 2024 | | Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны төслийг хэрэгжүүлэх хүрээнд нийгэм эдийн засгийн судалгаа, тооцоог хийнэ. | Орон сууцны эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд: Тус яамнаас Дэлхийн банкинд 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах эрх зүйн орчныг сайжруулах техник туслалцааны дэмжлэг авах хүсэлтийг тавьж, дэмжүүлсний дагуу төслийн ажлын даалгаврыг боловсруулан 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 4/1877 дугаар албан бичгээр Дэлхийн банкинд хүргүүлж, төслийн хэрэгжилтийг албан ёсоор эхлүүлсэн. Техник туслалцааны төсөл нь нийт 2 үе шаттайгаар хэрэгжих бөгөөд эхний үе шат нь 2021 оны 05 дугаар сараас 2022 оны 06 дугаар сарын хооронд хэрэгжих ба энэ хугацаанд холбогдох судалгаа, мэдээллээр хангаж, холбогдох уулзалтуудыг зохион байгуулж байна. Төслийн эхлэлтийн тайланг 2021 оны 9 дүгээр сард хүлээн авсан. Мөн Бүгд Найрамдах Сингапур Улсын Хамтын ажиллагааны байгууллагатай хамтран Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хөгжлийн талаарх хүний нөөцийн чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр албан уулзалтыг зохион байгуулж ажилласан. БНСингапур Улсын Темасек сангаас тус саналыг хүлээн авч зөвшөөрсөн бөгөөд нийт 232,400 сингапур долларын өртөг бүхий чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг 2022 онд хамтран хэрэгжүүлэх болсныг 2021 оны 12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 08-ны өдөр мэдэгдсэн. Түүнчлэн Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах хүрээнд СЯ, ХНХЯ-тай хамтран ажиллаж, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд “9.1.3.төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах." гэсэн нэмэлт, өөрчлөлтийг УИХ-аар 2021.11.12-ны өдөр батлуулсан. | |
| 41 | 3.7.10. Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 4-6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулна. | 1. Бага, дунд орлоготой иргэдийг жилийн 4-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлж, зээл олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна. | 2020 - 2024 | | Бага, дунд орлоготой иргэдийг жилийн 4-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд хамруулах дүрэм журам, гэрээг шинэчлэн боловсруулж, зээл олгох ажлыг эхлүүлнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд Монголбанк, Засгийн газар хамтран 2013 оны 6 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг тогтвортой хэрэгжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлийн хүрээнд орон сууцжуулах, ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрийг тогтвортой үргэлжлүүлэх арга хэмжээний талаарх танилцуулгыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар танилцуулан, 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/642 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэн шийдвэрлүүлсэн. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудад нийт 1.012.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13,292 зээлдэгчид олгосноос 81.9 хувь буюу 789.4 тэрбум төгрөгийн 9,550 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 18.1 хувь буюу 174.6 тэрбум төгрөгийн 3,159 зээлийг орон нутагт олгосон байна. Мөн тус хугацаанд гарсан 964.0 тэрбум төгрөгийн зээлийн 600.7 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 363.3 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжиж 2020 онтой харьцуулахад даруй 2.5 дахин өндөр үзүүлэлттэй амжилттай хэрэгжүүлсэн байна. Цаашид ипотекийн зээлийн хөтөлбөрийг тогтвортой явуулах хүрээнд 2022 онд нийт 200.0 тэрбум төгрөгийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засгийн газраас ипотекийн зээлийн эх үүсвэрт тусган шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | |
| 42 | 3.7.11. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ. | 3. Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | | 10 аймгийн төвийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох зураг төслийг боловсруулж батлуулна. | Аймгийн төвийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох зураг төслийн ажлыг 8 аймгийн төвийн 8 сум, 2 аймгийн 2 суманд хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Завхан аймгийн төвийн Гадна инженерийн шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ТЭЗҮ-ийн зураг төсөл 2.Хөвсгөл аймгийн төвийн Гэр хорооллын хэсэгчилсэн болон төвлөрсөн инженерийн хангамжийн зураг төсөл 3.Ховд аймгийн төвийн Гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл 4.Өвөрхөнгай аймгийн төвийн Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл 5.Хэнтий аймгийн төвийн Инженерийн шугам сүлжээг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх ажлын зураг төсөл; 6.Сүхбаатар аймгийн төвийн Гадна инженерийн шугам сүлжээний шинэтгэл, өргөтгөлийн ажлын зураг төсөл; 7.АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Өвөрхангайн Хужирт сумын цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ухаалаг ус түгээх байрны зураг төсөл Хяналт удирдлагын ухаалаг, автомат үйл ажиллагаатай Тайшир-Алтай ус хангамжийн системийг 2021.11.11-ний өдөр ашиглалтад оруулаад байна.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 43 | | 4. "Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, цэвэр ус дамжуулах шугам, дагалдах тоног төхөөрөмж, ус цэвэршүүлэх станцыг барьж ашиглалтад оруулна. | 2020 - 2021 | 3,050.77 сая төгрөг, Төсөл хөтөлбөр | Тайшир-Алтай ус хангамжийн системийг ашиглалтад оруулна. | БНАУ-ын “Ти Ар Эм” ХХК болон “Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо” мэргэжлийн төрийн бус байгууллага хамтран инженер, техникийн ажилтнуудад зориулсан ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг 2021.09.27-ноос 2021.12.05-ныг хүртэлх хугацаанд ИТА-ын, лабораторийн ажилтануудын, засварчин машинистуудын онолын болон дадлагын гэсэн 4 үе шаттайгаар зохион байгуулсан нийт 26 хүн хамрагдсан. Төслийн БУА-ыг 2021.11.30-нд багтаан дуусгах 2021/101 тоот нэмэлт гэрээг 2021.04.15-нд байгуулсан. Техникийн комисс 2021.10.05-нд, улсын комисс 2021.11.24-нд ажиллаж, 2021/01-06 дугаар комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт : 1 файл | |
| 44 | | 5. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. /58.5 сая ам.доллар,/ | 2020 - 2024 | | Төслийн хэрэгжилт 60 хувьд хүрнэ. | АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь аймгийн төвд цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Дархан, Дорноговь, Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлууд 60-85%-ийн хэрэгжилттэй үргэлжлэн хэрэгжиж байна. Өвөрхангай, Хужирт сумын цэвэрлэх байгууламжийн болон цэвэр, бохир усны өргөтгөл шинэчлэлтийн ажлыг “Санжат” ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 75%. Дундговь, Эрдэнэдалай сумын бохир ус цэвэрлэх байгууламж, шугам сүлжээний ажлыг “Сайн констракшн” ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 85%. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй төслийн хэрэгжилт 85%.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 45 | | 6. Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/ | 2020 - 2024 | | Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, зураг төслийг боловсруулж, төслийг эхлүүлнэ. | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улс (БНПУ)-ын Засгийн газар хооронд 2017.05.09-нд байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл /Баян-Өлгий, Увс, Завхан, Дорнод, Говьсүмбэр/”-ийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. гүйцэтгэгчээр БНПУлсын “Эй Би Индастри” ХХК (түншлэлийн толгой компани), “Смарт Уэйст Технологи” ХХК (түншлэлийн гишүүн), Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэгчээр БНПУлсын “Мелиорекс” ХХК шалгарч, Дорнод 2021/220, Баян-Өлгий 2021/221, Говьсүмбэр 2021/222, Увс 2021/224, Завхан 2021/223 дугаар гэрээг байгуулсан. Төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх “Ажлын хэсэг”-ийг 2021.11.25-ны Төрийн нарийн бичгийн даргын А/139-р тушаалаар байгуулсан. Говь-Алтай, Баянхонгор аймгийн төв болон УБ хотын Багануур дүүргийн цэвэрлэх байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих ажлын даалгаварыг боловсруулж батлуулан, 2022 оны ТЭЗҮ, зураг төслийн хөрөнгийн хүрээнд 650.0 сая төгрөг шийдвэрлүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт : 1 файл | |
| 46 | 3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 3. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | УБ хотын хэмжээнд 53 байршилд 150 км үерийн усны далан сувагтай. Үүнээс 2021 онд 5,4 км үерийн усны далан суваг шинээр ашиглалтад орсон. 1.СБД-ийн 13, 14-р хороонд 618 м үерийн далд сувгийн ажлыг гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 95%. 2.БЗД-ийн 21, 27-р хороонд үерийн хамгаалалтын сувгийн түшиц ханын арматурчлал, хэв хашмалын ажлын гүйцэтгэл 100%. 3.ЧД-ийн 13-р хороо, “Хайлаастын авто замын ус зайлуулах хоолой суваг”-ийн зураг төслийг боловсруулсан. Ус зайлуулах сувгийн ажлын гүйцэтгэл 85%.<br><br>Хавсралт : 1 файл | 90% |
| 47 | | 4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | Үерийн хамгаалалтын барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлнэ. | 1.Хэнтий, Цэнхэрмандал сумын үерийн далан сувгийн 1657.1 м газар шорооны ажлыг "Эн Пи Эл" ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70%. 2.Хэнтий, Хэрлэн сумын үерийн далан сувгийн ажлын гүйцэтгэл 100%. Гүйцэтгэгч "Усны барилга" ХХК. 3.Баян-Өлгий, Өлгий сумын үерийн усны хамгаалалтын далан сувгийн ажлыг "Нью констракшн" ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70%. 4.Баянхонгор аймгийн төвийн 2, 7-р багийн үерийн хамгаалалтын далан сувгийн ажлыг “Эвт-Уул” ХХК гүйцэтгэж 100% дууссан. 5.Булган, Сайхан суманд хэрэгжих үерийн хамгаалалтын далан сувгийн ажлыг “Цэгц Бэрс” ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 80%.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 48 | 3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, | 1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ. | 2020 - 2024 | | Барилга ажлыг бүрэн дуусгаж, тоног төхөөрөмж суурилуулсан байна. | Тус төслийн барилга угсралтын ажил дуусгаж, тоног төхөөрөмжүүдийг суурилуулаад байна. Мөн Дээрх төсөл нь "Бэрэн групп" ХХК нь “Бэрэн майнинг” ХК, “Ар ган” ХХК, “Хөх ган” ХК-д нийт 59.5 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр, “Бэрэн металл” ХХК-д 143.4 тэрбум төгрөгийг өөрийн болон банк, санхүүгийн байгууллагын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн домен зуухаар гангийн үйлдвэрийн гол түүхий эд болох ширэм үйлдвэрлэж байна. Эцсийн бүтээгдэхүүн буюу арматур үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг шийдвэрлэхэд тус яамнаас | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. | | | | | дэмжлэг үзүүлэн Хөгжлийн банктай хамтран ажиллаж байна. Барилгын материалын гол нэр төрөл болох арматурын үйлдвэрлэлийг дэмжиж холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусгаад байна.<br><br>Хавсралт нийт : 6 Файл : 3 Зураг : 3 | |
| 49 | | 2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна. | 2020 - 2024 | | Шилний үйлдвэр барих төсөл боловсруулж холбогдох газарт хүргүүлнэ. | Монгол Улсад хавтгай шилний үйлдвэр байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Эрдэс плазм” ХХК-ийн шилний үйлдвэрийн төслийг холбогдох байгууллагуудад хүргүүлж дэмжиж ажиллах хүрээнд Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.12. “Тэргүүлэх чиглэлийн 100 төсөл, арга хэмжээнд тусгуулан ажиллаж байна. Мөн “Эрдэс плазм” ХХК-ийн шилний үйлдвэрийн төслийг дэмжин ажиллах бодлогын хүрээнд үйлдвэрлэл, технологийн паркын орчинд орж ажиллах боломж, давуу талыг танилцуулснаар тус компанид Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 227 дугаар тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгогдож, үйл ажиллагааг эхлүүлээд байна.<br><br>Хавсралт : 4 файл | 100% |
| 50 | | 3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна. | 2020 - 2024 | | Цементийн үйлдвэрийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ. | Ховд аймагт цементийн үйлдвэр байгуулах "Вестерн холд" ХХК-ийн хөрөнгө оруулалтыг зээлээр шийдвэрлэх талаар санал боловсруулж Хөгжлийн банкинд 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01/537 тоотоор уламжилснаар тус төсөл Хөгжлийн банкнаас 20 сая ам.долларын зээл авч барилга угсралтын ажлаа гүйцэтгэж, барилга угсралтын ажил бүрэн дууссан. Гүйцэтгэл 100%-тай байна. Тоног төхөөрөмж суурилуулах ажил эхэлсэн. БНХАУ-аас 2021 онд 45 мэргэжилтэн урьж ажиллуулсан. Эдгээр гадаадын ажиллах хүч 5-6 сард ирж, барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралтын ажилд оролцсон. 2022 онд ажиллуулах Хятад ажилчдыг ирүүлэх хүсэлтийг ХНХЯ-нд уламжлан шийдвэрлүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |

| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 51 | 4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | 3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2021 - 2024 | | Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ. | ТАЗ-ийн 2 удаагийн хэлэлцүүлэгт оролцож, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмд оруулах өөрчлөлтийн саналыг хүргүүлсэн. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б70 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 52 | 4.2.7. Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална. | 6. Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2021 - 2024 | | Барилга, хот байгуулалтын салбарын хэмжээнд Жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилт, эмэгтэйчүүд, охидын хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны дарамт зэрэг тулгамдсан | Барилга, хот байгуулалтын салбарын хэмжээнд Жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилт, эмэгтэйчүүд, охидын хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны дарамт зэрэг тулгамдсан асуудлын талаар судалгаа хийж, жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, хүний нөөцийн талаар мэдлэг түгээх ажлын хүрээнд “Барилга, хот байгуулалт ба жендэр” сургалт, “Барилгын салбар зөвхөн эрчүүдийн ертөнц гэж үү?, "Уур амьсгалын өөрчлөлт ба жендэр”, Монголын барилгын салбар дах жендэрийн талаарх ташаа ойлголтоос хэрхэн ангижрах вэ?” сэдэвт судалгааны ажилд салбарын 118 албан хаагчдыг хамруулсан. ЖҮХ-ны Ажлын албанаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээ, Жендэрийн салбар хороодын ажлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, зөвлөмжүүдийг яамны харьяа болон 21 аймгийн ЗДТГ-т 2021.5.25-ны 3/1978 тоот албан бичгээр хүргүүлж, зөвлөмж, чиглэл өгч ажилласан. Жендэрт суурилсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | асуудлын талаар судалгаа хийж, жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, хүний нөөцийн талаар мэдлэг түгээнэ. | хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд харьяа байгууллагууд, ТББ, яамны албан хаагчид “Хүчирхийллийн эсрэг тууштай зогсож, дуу, хоолойгоо өргөе! Үг, үйлдлээрээ үлгэрлэе! # Та ч бас” уриатайгаар нэгдэх ажлыг зохион байгуулж, яамны вебсайт, олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчилан ажилласан. Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн 2021 үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан 12 харьяа байгууллагууд, ТББ-дад албан бичгээр хүргүүлэн, хэрэгжүүлж ажилласан. Барилгын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох сургалтын нэгдсэн хөтөлбөрт Жендэрийн талаар мэдлэг ойлголт өгөх, Барилга, дэд бүтэц ба Жендэр сургалтыг ИТА-д сонгон суралцахаар тусгаж, батлуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 53 | 4.2.10. Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. | 2. Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, Барилгын материал үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, Барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох зэрэг төрийн эрхлэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх болон Барилгын салбарын 3 талт хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг | 2021 - 2024 | | - | “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн хуралдааныг 2021.2.9-ний өдөр зохион байгуулж, өмнөх оны тайлан, сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө, сургалт эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан тайланг тус тус хэлэлцүүлсэн. Орон тооны бус зөвлөлийн хуралдааныг 2 удаа зохион байгуулсан. 56 төрлийн хүрээгээр хийсэн сургалтын нэгдсэн төлөвлөгөөг олон улсын түвшинд мэргэшсэн, зөвлөх инженер бэлтгэх хэмжээнд боловсруулах зөвлөгөөг өгч, Эрчим хүчний хэмнэлттэй, Ногоон барилгын төлөвлөлт, зураг төсөл боловсруулах, барих үйл ажиллагааг удирдлагаар хангах, Жендэрийн эрх тэгш байдлыг барилгын салбарт хэрэгжүүлэх арга зам, Хувь хүний зөөлөн ур чадварыг хөгжүүлэх зэрэг сургалтуудыг шинээр хөтөлбөрт тусгуулав. Төрийн нарийн бичгийн даргын 2021.3.26-ны өдрийн А/50 дугаар тушаалаар Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө, Барилгын салбарын ажилтны мэргэшлийн зэрэг горилох, сунгах шалгалтын төлөвлөгөө, “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус хянан батлуулж, хэрэгжилтийг удирдлага, зөвлөмжөөр хангав. Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, нийтийн аж ахуй, барилгын материал үйлдвэрлэлийн салбарын 158 сургалтад 2080 ИТА-ыг хамруулж, ТНБД-ын 2021 оны А/84, А/132 зэрэг 3 удаагийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | удирдлага, зохион байгуулалтаар хангана. | | | | тушаалаар 671 ИТА-д шинээр мэргэшлийн зэрэг олгож, 395 ИТА-ийн мэргэшлийн зэргийг сунгуулсан. Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээрийн төслийг хянан боловсруулж, гэрээ байгуулсан. БХБС болон аймаг, Нийслэлийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаарх гэрээ байгуулж, гэрээнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 2 файл | |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 54 | 5.1.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | 4. Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020 - 2024 | | Ус, дулаан, цахилгаан, холбоо дохиоллын шугам сүлжээний зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлнэ. | Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд 1.Туул-1 коллекторын трассд зайлшгүй шаардлагатай 22 байршилд БХБСайдын 2021 оны төсвийн багцаас 15,0 сая төгрөгийг шийдвэрлэж нарийвчилсан судалгаа хийж, байр зүйн зураг төслийг боловсруулаад байна. Мөн гүйцэтгэл хийгдээгүй 9.3 км трассын газрыг чөлөөлөх боломжгүй хэсэгт ажлын зурагт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Энэ төсөлд Нийслэлийн төсвөөс 3,2 тэрбум төгрөг шийдвэрлүүлсэн.. 2.СБД-ийн 18-р хороо, “Бичил дэд төв”- төслийн 1-р үе шатны ажил 95%.хэрэгжүүлж байна. 3.СХД-ийн 30-р хороо, “Хилчин” хотхоны ус, дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний ажлыг дууссгасан. 4. ХУД-ийн Нэхмэлийн шар байр орчмын дахин төлөвлөлтийн хүрээнд гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 2021.09.15-ны ШС-171/2021 дугаар комиссын шийдвэрээр ашиглалтад оруулсан. 5. “Залуус” орон сууцны цогцолборын Дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ урьдчилсан судалгаа, дулааны ачаалал, тооцоолол, цахилгаан хангамжийн зураг төслийн боловсруулалт хийж дуусч /90%/-тай байна. Угсралтын ажлууд нь төлөвлөсөн хугацаандаа эхлэх боломжтой болж байгаа юм.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 55 | 5.1.4. Гэр | 1. Гэр хорооллын | 2020 - | | Улаанбаатар | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар УБ хотод дараахь 5 төсөл, арга | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ. | 2024 | | хот болон төв суурин газрын 1000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна. | хэмжээг хэрэгжүүлэн 2924 айлыг сайжруулсан, био жорлонтой болгох ажлыг эхлүүлж 2030 айлд суурьлуулж, ашиглалтанд оруулсан, ажил үргэлжлэн хийгдэж байна. Үүнд: ЧД-ийн “Эко хороо” төслийн хүрээнд нийт 73 айлд био жорлон суурилуулсан. . ЧД-ийн 7, 8, 9, 10, 11-р хороонд хэрэгжиж буй “Шинэ хороо" төслийн 57 айлд био жорлон суурилуулсан. ХУД-ийн “Гэр хорооллын нүхэн жорлон шинэчлэх ажил”-ын хүрээнд 700 айлд суурилуулсан. БЗД-ийн 20-р хороонд 1050 айлд хөрсөнд нэвчдэггүй жорлон суурилуулахаас 600 айлд суурилуулсан. СХД-ийн 23, 39-р хорооны 40 айл “Шинэ хороо” төсөлд хамрагдсан. БЗД-ийн 9, 17, 19, 24, 22-р хороонд 600 айлд сайжруулсан ариун цэврийн байгууламжийг суурилуулж дууссан.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 56 | | 2. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тогтвортой менежментийг хангах стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тогтвортой менежментийг хангах стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулна. | Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн тогтвортой менежментийг хангах арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилт, 23 арга хэмжээтэйгээр боловсруулж, 2021.10.20-нд сайдаар батлуулан холбогдох байгууллагуудад 2021.10.25-ны 3/4197 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2021 онд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 57 | 5.1.9. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх, аюултай хог хаягдлыг | 1. Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулна. | 2021 - 2024 | | Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах газрын асуудлыг шийдвэрлэсэн байна. | Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 07 тоот тушаалаар Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах газрын асуудлыг судлах, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг Нийслэл, Төв аймагт Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих зориулалтаар газрыг судалж Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 20 га, Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт 10 га газрын 2 байршлыг сонгон газрыг улсын тусгай хэрэгцээнд авахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авч ирүүлэх тухай албан бичгийг 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/907 тоот албан бичгээр хүргүүлсэн. Ажлын хэсгээс Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар улсын тусгай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах үйлдвэр байгуулна. | | | | | хэрэгцээнд авахаар урьдчилан сонгосон Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг хүн, амьтны эрүүл мэнд болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхээр шийдвэрлэж БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ажлын хэсгийн гишүүн /Г.Энхмөнх/-д үүрэг болгож, Барилга, хот байгуулалтын дэд сайд, ажлын хэсгийн ахлагчийн 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2/4899 тоотоор хурлын шийдвэрийг тус яаманд албан бичгээр хүргүүлсэн. Хавсралт : 1 файл | |
| 58 | 5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна. | 2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана. | 2020 - 2024 | | Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулна. | БОАЖЯ, Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)-ын нарийн бичгийн газар, Даян дэлхийн Байгаль орчин, Стратеги судлалын хүрээлэнгээс 2021-01-21-ний өдөр хамтран зохион байгуулсан “ПАРИСИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН 6.2-Р ЗҮЙЛ: Хамтарсан Кредит Олгох Механизм, Тогтвортой хөгжлийн зорилт” сэдэвт цахим хуралд оролцож, хамтын ажиллагаа, салбар тус бүрийн хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Барилгын салбарын Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний саналыг тусгуулахаар БОАЖЯ-нд 2021.05.14-ний өдрийн 1/1737 тоот албан бичгээр хүргүүлсэн. Арга хэмжээний төлөвлөгөөг Уур амьсгалын Үндэсний хорооны 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/21 тогтоолоор баталсан. -Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл (3-р үе шат)-ийн Хамтарсан Зохицуулах хорооны хурлыг 2021.01.28-ны өдөр цахимаар зохион байгуулахад БХБЯ-ыг төлөөлөн оролцсон. -“Парисын хэлэлцээрийн хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт” бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын уулзалтыг 2021.01.29-ний өдөр цахимаар зохион байгуулж, салбарын үйл ажиллагааны талаар танилцуулга бэлтгэн, илтгэл тавилаа. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах салбарын төлөөлүүдтэй зөвлөлдөж, хэлэлцсэн. - БОАЖЯ, Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын Хүлэмжийн хий, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | агаар бохирдуулагч хүлэмжийн хийн ялгарал, тэдгээрийг бууруулах хувилбаруудад дүн шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд “Бага ялгарлын шинжилгээний платформ LEAP-ийн талаар оролцогч талуудад мэдлэг олгох” цахим сургалт 2021.03.16-19-ний өдрүүдэд зохион байгуулагдаж тус яамнаас холбогдох мэргэжилтнүүд оролцсон.<br><br>Хавсралт : 3 файл | |
| 59 | | 6. Барилгын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлж, хэрэгжүүлнэ. | 2020 - 2024 | | Арга хэмжээг тодорхойлсон байна. | - Барилгын салбарын Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч нартай 2021.02.21-ний өдөр цахим уулзалт зохион байгуулж, ажлын явц, төлөвлөгөөний төсөлтэй танилцаж холбогдох санал өгсөн. - “Барилгын салбарын Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 2021-2030”-ний төслийг Салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд, холбогдох мэргэжлийн байгууллагууд, бусад яамдын асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх, хэлэлцүүлгийг 2021.03.04-05-ны өдрүүдэд зохион байгуулав. Хэлэлцүүлэг 2 өдөр үргэлжилж, 80 гаран төлөөлөл оролцсон. Төлөвлөгөөний төслийг 2021.03.09-ний өдөр яамны албан хаагчдад танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулж, санал зөвлөмжийг авсан. Мөн “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэлэлцүүлэг” –ийг 2021.03.12-ны өдөр БХБЯ-ны хурлын зааланд зохион байгуулж, салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохоор тус яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудын албан хаагчид төслийн шатанд хэлэлцэж, санал солилцсон. Саналыг тусган дахин хэлэлцүүлэхээр зар хүргүүлсэн. Ирүүлсэн саналыг тусгасан төлөвлөгөөний төслийг 2021.07.06-07-ны өдрүүдэд яамны нэгжүүд хуваарийн дагуу цахимаар хэлэлцэж, санал өгсөн. “Барилга, хот байгуулалтын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г Барилга, хот байгуулалтын сайдын 2021.07.22-ны өдрийн 166 дугаар тушаалаар баталсан. Яамны нэгжүүд болон харьяа байгууллагуудыг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах чиглэл өгөн ажиллаж байна. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн тооцоолол, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 61 | | | | | | холбогдох мэдээллийг Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч багаас эцсийн байдлаар 2021.11.30-ний өдөр акт үйлдэн хүлээж авав.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 60 | | 7. Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох, цахим системийг нэвтрүүлнэ. | 2020 - 2024 | | Цахим системийг хөгжүүлнэ. | Барилга, хот байгуулалтын сайдын 2021.05.18-ны өдрийн 114 дүгээр тушаалаар Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, судалгааг бий болгох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүний үр дүнг хэмжих, тайлагнах, нотлох боломжийг бүрдүүлэх зорилго бүхий “Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим систем”-ийн мэдээллийн санг баяжуулах, сайжруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 5 удаа зохион байгуулж, “Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим систем”-ийг хөгжүүлэх “Ажлын даалгавар”-ын төслийг боловсруулан, ажлын хэсгийн гишүүдийн саналыг тусган төслийг санхүүжүүлэгч ГОУХАБ /GIZ/-д хүргүүлсэн. 2021.09.24-ний өдөр дэлгэрэнгүй жагсаалтад нэр орсон 9 байгууллагад Тендерийн урилга хүргүүлсэн. 10 дугаар сарын 24-ны өдөр тендерийг хүлээн авч нээж, үнэлсэн. Батлагдсан ажлын даалгаварын дагуу тендер зарлаж, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр “Софт мастер” ХХК шалгарч, санхүүжүүлэгч байгууллага болох ГХАОУБ-тай 11 сард гэрээ байгуулсан. Одоо ашиглагдаж буй системд хийсэн шинжилгээ, системийг сайжруулах шийдэл, түгээгч байгууллагуудтай мэдээлэл солилцох боломж, тулгамдаж буй асуудлын талаар ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэн. “Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим систем”-ийн мэдээллийн санг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сантай уялдуулах боломж, хэрэглээний талаар хэлэлцүүлгийг яамны Хурлын танхимд 2021.12.02-ны өдөр зохион байгуулав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 61 | 6.1.9. Хог хаягдлын | 2. Ядуурлыг бууруулах Японы | 2021 - 2023 | | Төслийн хэрэгжилт 70 | Төслийн 4 аймгийн ажлын зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | менежментийг сайжруулж, гэр хорооллын айл өрхийг үнс хадгалах зориулалтын савтай болгож, дахин боловсруулах бүх төрлийн үйлдвэрийг байгуулна. | сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хот хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ. | | | хувьд хүрнэ. | үнэлгээний дүгнэлтийг 4 аймагт хийж, 2021.09.28-нд БОАЖЯ-аар батлуулсан. Сүхбаатар, Говь-Алтай аймагт хяналттай ландфиль барих ажилд зохиогчийн хяналтыг 2 удаа хийж, 2021.12.02-нд эцсийн дүгнэлт гаргасан. Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн ИТХ-д Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний тайланг хэлэлцүүлж, улмаар АХБ-нд хүргүүлсэн. Төслийн хэрэгжилт 76%. Барилга угсралтын ажил: Сүхбаатар аймгийн ландфиллийг 2021.12.09-нд, Говь-Алтай аймгийн ландфиллийг 2021.12.15-нд улсын комисс ажиллан ашиглалтад оруулсан. Дархан-Уул аймгийн төвд дахивар нөөцийн цэг барих ажлын тендерийг 2021.09.24-нд зарлаж, “Гурван Бүрэн” ХХК шалгарч 2021.10.28-нд гэрээ байгуулсан. Хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүү ба дахивар нөөцийн цэг барих ажлын тендерийг Говь-Алтай аймагт 2021.11.10-нд, Сүхбаатар аймагт 2021.11.12-нд, Өвөрхангай аймагт 2021.11.25-нд үнэлж, АХБ-нд хүргүүлсэн.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 62 | 6.1.10. Улаанбаатар хотын цэвэр усны шинэ эх үүсвэрийг бий болгож, "Төв цэвэрлэх байгууламж"-ийг шинээр барьж ашиглалтад оруулан, тус цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг дулааны III, IV цахилгаан станцын технологийн | 1. АНУ-ын МСК-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барьж, ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | | Төслийн хэрэгжилт 6 хувьд хүрнэ. | АНУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Компакт гэрээний хүрээнд УБ хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр БНТУ-ын MAPA INSAAT Ve TICARET AS компани шалгарч 2021.08.02-нд гэрээ байгуулсан. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлыг 2021.08.20-нд эхлүүлж, 5 барилгын суурийн газар шорооны ажлыг гүйцэтгэж байна. Төслийн хэрэгжилт 15%.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 63 | | 2. Улаанбаатар хотын шинэ цэвэрлэх байгууламжийг барьж, ашиглалтад оруулна. | 2020 - 2024 | | Төслийн хэрэгжилт 30 хувьд хүрнэ. | Зураг төсөл: Барилга байгууламжийн зураг төслийг Шанхай хотын зураг төслийн хүрээлэн боловсруулсан. Нийт 38 объектийн зураг төсөл хийгдэхээс 11 барилга нь магадлалаар хянагдсан. Бусад нь хянагдаж байна. 98%-ийн гүйцэтгэлтэй. Цахилгааны 35/10кВ-ын дэд станц, ЦДАШ, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугамын зураг төслийг боловсруулж, батлуулсан. БУА: 25%-ийн гүйцэтгэлтэй. Элс баригч, 1-р 2-р тунгаагуур, хойд биореактор, захиргааны барилга, лаг өтгөрүүлэгч, лаг өтгөрүүлэгч, метантенк зэрэг 12 барилгын БУА | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгцээнд ашиглана. Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартад нийцсэн бие даасан цэвэрлэх байгууламж бүхий ноолуурын үйлдвэрүүдээс бусдыг хотоос гаргаж, Ус сувгийн удирдах газрын харьяа урьдчилсан цэвэрлэх байгууламж Харгиаг татан буулгана. | | | | | хийгдэж байна. Тоног төхөөрөмж татан авалт: Нийт 17 гэрээг үйлдвэрлэгч нартай байгуулсан. Ажиллах хүчин: 2021.06.19-ний өдөр 35 ИТА-г оруулж ирсэн. Дотоодын туслан гүйцэтгэгч 13 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажиллуулсан. Сургалтууд зохиогдсон. КОВИД –ын үед ажиллах түр журам, төлөвлөгөөг батлуулж, ажилласан. УБ хотын төв цэвэрлэх байгууламжийн төслийн 2021 оны жилийн эцсийн тайлангаар хэрэгжилт 35%-тай.<br><br>Хавсралт : 2 файл | |
| 64 | | 3. Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах төслийг хэрэгжүүлнэ. | 2021 - 2025 | | Төслийн хэрэгжилт 15 хувьд хүрнэ. | Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төслийн зөвлөхөөр ХБНГУ-ын “Фихтнер Ватер энд Транспортэйшн” компани шалгарч, 2021.08.04-нд гэрээ байгуулсан. Төслийн зөвлөх компани ус дамжуулах шугам хоолой, холбогдох дэд бүтэц, ДЦС-3 болон ДЦС-4-ийн техникийн усны өөрчлөлтийн зураг төсөл боловсруулах, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх, ус дамжуулах шугам хоолойн трассын дагуу нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах багц ажлыг гүйцэтгэж байна. Төслийн хэрэгжилт 15%.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 65 | 6.2.2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдэх | 2. Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангана. | 2021 - 2024 | | 3,381.0 | 21 аймгийн лабораторийн тоног төхөөрөмжүүдийг үе шаттай сайжруулахаар бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Монгол Улсын Засгийн газраас баталсан “Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”-н хүрээнд 21 аймагт керамик эдлэхүүний лаборатори, бетон дүүргэгч материалын лабораториуд, БХБЯ-аас БМСШЛабораторид Метал хийц эдлэхүүний, Холбогч материалын, Бетон дүүргэгч материалийн гэсэн 3 лабораторийн хүчин чадлыг 28 иж бүрдэл дэвшилтэд техник тоног төхөөрөмжөөр өргөтгөн сорилт шинжилгээний тоо хэмжээг нэмэгдүүлсэнээс 2021 оны байдлаар 48 нэр төрлийн 13014 ширхэг дээж хүлээн авч сорилт шинжилгээ хийж үр дүнг гаргасан байна. “Барилгын материалын лаборатори”-ийг 21 аймаг, Замын-Үүд боомтод байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтын талаар танилцуулга бэлтгэн, Азийн хөгжлийн банканд 2021 оны 1 дүгээр сард | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | суурь нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | танилцуулж, холбогдох төсөв, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн судалгааг хүргүүлээд байна. Өнөөдрийн байдлаар 17 аймгийн төвд 3 нэр төрлийн лаборатори: Үүнд – Архангай, Ховд, Дорноговь, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Өвөрхангай, Орхон, Баянхонгор, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар, Өмнөговь, Завхан, Хэнтий, Дундговь аймгуудад -Бетон дүүргэгч материалын, Керамик эдлэхүүний, Холбогч материалын лаборатори ажиллаж байна. Өмнөговь, Говьсүмбэр аймагт цонх, арматур, цемент, керамик эзлэхүүний лабораторийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулж ажиллаж байна. Мөн 2021 оны 12 дугаар сарын 03-нд Баян-өлгий аймаг Металл эдлэхүүний лаборатори, Вакум цонх, Бетон дүүргэгч, Цементийн, Арматурын лабораторын тоног төхөөрөмжүүдийг суурилуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Орон нутагт баригдаж байгаа барилгад ашиглагдах барилгын материал, хийц бүтээц, эдлэхүүний чанарт лабораторийн хяналтыг хэрэгжүүлэх замаар барилгын чанар, аюулгүй байдлыг хангуулах нөхцлийг бүрдүүлж байна. | |
| 66 | | 3. Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийг өргөх машин механизм, цахилгаан утасны лаборатори, барилгын физикийн лабораторийн тоног төхөөрмжөөр хангана. | 2021 - 2023 | | 50.0 | Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагаанд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүдийг худалдан авах үнэлгээний хороог БХТөвийн захирлын 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А/120, А/139 дүгээр тушаалаар тус тус байгуулсан. Шинжилгээнд шаардлагатай 25 нэр төрлийн 106 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авах үйл ажиллагааг 3 багц болгож ангилсан. Үүнд: 1. Хүйтэн тэсвэрлэлт тодорхойлох төхөөрөмжийн багцын тендер зарлагдан нийлүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулж БМСШЛ-д ирсэн суурилуулалт хийгдэж хүлээн авсан ашиглаж байна. 2. 11 нэр төрлийн 18 ширхэг тоног төхөөрөмжийн багцын тендер зарлагдан нийлүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулж 5 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэгдэн үлдэгдэл 13 ширхэг нь хүлээгдэж байна. 3.1. Шууд худалдан авалтаар чийгшүүлэгч камерын нийлүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулж БМСШЛ-д ирсэн суурилуулалт хийгдэж хүлээн авсан ашиглаж байна. | 100% |
| 67 | 6.2.7. Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам | 1. Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв | 2020 - 2024 | | Ажлын зураг төслийг гүйцэтгэж, | Ажлын зураг төслийг гүйцэтгэж, барилга угсралтын ажлыг 4 аймгийн суманд эхлүүлж, 3 аймаг дуусаж, 1 аймаг 98 %-тай нийт гүйцэтгэл 99,2%-тай хэрэгжиж байна. 1.Ховд, Булган сумын инженерийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | | | барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | нэгдсэн шугам сүлжээг “Жаргалант луу” ХХК гүйцэтгэсэн. Халаалтын зуухны барилгын ажил болон дулааны 4,9 км, бохир усны 5 км, цэвэр усны 8,3 км шугам сүлжээний ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 100%. 2.Сүхбаатар, Баруун-Урт сумын шугам сүлжээний шинэтгэл, өргөтгөлийн ажлын зураг төслийг “Монкузбасс” ХХК гүйцэтгэсэн. Цэвэр усны 4.8 км, ариутгах татуургын 1.7 км шугамын ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 100%. 3.Дархан-Уул, Дархан сумын гадна дулаан хангамжийн ажлын зураг төслийг “Инж Байгууламж” ХХК гүйцэтгэж магадлалаар баталгаажуулсан. Тосгон чиглэлийн гадна дулаан хангамжийн 550 м шугам сүлжээг угсарсан. Ажлын гүйцэтгэл 100%. 4.Завхан, Отгон сумын ИШС-ний барилга угсралтын ажлыг “Сэрвэн Овоот” ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 98%.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 68 | | 2. Сумын хөгжил арга хэмжээг хэрэгжүүлж, инженерийн дэд бүтцийг барьж байгуулна. | 2020 - 2024 | | Төслийг 5 сумын төвд хэрэгжүүлнэ. | Сумын хөгжил арга хэмжээний хүрээнд 2021 оны ТЭЗҮ, зураг төслийн хөрөнгөөс 5 сумын инженерийн дэд бүтцийн зураг төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн ажлыг эхлүүлж, 2 сумын ажил 100% дууссан, 3 сумын ажил хийгдэж байна. 1.Баянхонгор, Өлзийт суманд цэвэр усны 0,8 км, бохир усны 2,1 км, дулааны 0,8 км шугам сүлжээ, усан сан 2х50м3, 50м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг 2021.10.04-ний өдөр комисс ажиллаж ашиглалтад оруулсан. 2.Өвөрхангай, Хайрхандулаан суманд гүний худаг-2, дулааны 0,8 км, цэвэр усны 6,7 км, бохир усны 3,1 км шугам, усан сан 100 м3, ухаалаг ус түгээх байр 2, 50 м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг 2021.10.06-ны өдөр комисс ажиллаж ашиглалтад оруулсан. 3.Хэнтий, Галшар суманд гүний худаг 2, усан сан 2х50м3, цэвэр усны 2,3 км, бохир усны 1,6 км, дулааны 0,6 км шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж 50м3/хон хүчин чадалтай байхаар төлөвлөсөн. 2021 оны жилийн эцсийн байдлаар бохир усны 1,68 км, дулааны 0,6 км шугам, 400 кВа-ын цахилгааны ажил дууссан. Цэвэрлэх байгууламжийн 12 бетон худгийн ажил хийсэн. 4.Баянхонгор, Эрдэнэцогт суманд усан сан 25м3, бохир усны 2,5 км шугам, 60м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 2,5 км автозамын барилгын ажил төлөвлөгдсөн. 2021.10.05-нд автозамын зураг төслийг боловсруулж баталгаажуулан 1,4 км автозамын ажил бүрэн хийгдсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.Баянхонгор, Галуут суманд гүний худаг, 2 км дулаан, цэвэр усны шугам, 60м3 усан сан, бохир ус зайлуулах 2км урттай шугам, 60м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 2 км автозам барина. БУА нь 2021.09.10-нд эхэлж гадна дулаан, цэвэр усны 2 км шугам сүлжээний ажлаас 1.3 км хийсэн.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 69 | 6.2.9. Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулна. Аймгийн төвүүдийн гэр хорооллын айл өрхүүдийг ухаалаг тоолуурт шилжүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна. | 1. Бүс нутгийн томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ТЭЗҮ боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлнэ. /5 газар/ | 2021 - 2024 | 314.0 сая төгрөг, Улсын төсөв | ТЭЗҮ, зураг төсөв боловсруулсан байна | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XI.4.2 тусгадсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 32 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтын 39-д “Бүс нутгийн нүүрсний томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан түлшний үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэл /5 газар/ төсөл, арга хэмжээний хүрээнд “Эдийн засгийн эрчим хүчний хүрээлэн” ТӨААТҮГ-тай 314,0 сая төгрөгийн гэрээ байгуулсан ба зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж дуусган Эрчим хүчний яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021 оны 12-р сарын 7-р хуралдааны 6-р тэмдэглэлээр баталгаажуулж, ЭХЯ-нд хүлээлгэн өгсөн байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 70 | 6.2.11. Хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих замаар сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг | 1. Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төвийг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | | 6 аймгийн 6 сумын төвийг нийтийн халуун ус, ахуйн үйлчилгээний төвтэй болгоно. | Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төв бий болгох ажлын хүрээнд Булган, аймгийн 2 сум, Увс аймгийн 2 сум, Хөвсгөл аймгийн 3 сум, нийт 8 ажлыг эхлүүлж, 2 ажил дууссан байна. 1. Хөвсгөл аймгийн Тариалан сумын нийтийн халуун усны барилгын ажлын зураг төслийг боловсруулан, ажлыг гүйцэтгэж 2021.12.06-нд ашиглалтад оруулсан. 2. Увс аймгийн Бөхмөрөн сумын халуун усны барилгын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 2021.07.30-нд байнгын ашиглалтад оруулсан. 2. Булган | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулна. | | | | | аймгийн Хишиг-Өндөр, Баяннуур сумын нийтийн халуун усны зураг төслийг боловсруулж магадлалаар баталгаажуулсан. Барилга угсралтын ажил явагдаж байна. 3. Хөвсгөл аймгийн Баянзүрх, Алаг-Эрдэнэ сумын халуун усны зураг төслийг “Гранд лайн прожект” ХХК боловсруулж, баталгаажуулсан, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт 3 удаа зарлагдсан. Баянзүрх сумын халуун усны барилгын гүйцэтгэгчээр “Ану булаг” ХХК шалгарсан. 2021.08.10-нд гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил явагдаж байна. 4. Увс амйгийн Зүүнхангай сумын Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилгын зураг төслийг боловсруулж, магадлал хийсэн. Барилгын ажлын тендерийг дараа зарлаж хугацаа алдсан ч гүйцэтгэгчийг шалгаруулсан. 6. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын халуун усны барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2021.08.10-нд гэрээ байгуулж, барилга угсралтын ажил явагдаж байна.<br><br>Хавсралт : 1 файл | |